



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 7/18

Бат-Өлзий сум

Г Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг  
түр зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан хүчтэй цасан шуурга шуурч зам даваа хаагдаж авто тээврийн хэрэгслээр зорчиход аюултай нөхцөл байдал үүссэн тул, Хот хооронд болон бусад чиглэлд зорчих хөдөлгөөнийг 2024 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн цаг агаарын нөхцөл байдал сайжирч, авто замаар аюулгүй зорчих нөхцөл бүрдэх хүртэлх хугацаагаар түр зогсоосугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг “Цэгээн хангайн зам” хязгаарлагдмал хариуцлагатай компани (Ч.Мандахбаяр), (багийн Засаг дарга нар, байгууллагын дарга, эрхлэгч), Цагдаагийн тасгийн дарга (цагдаагийн хошууч Д.Энх-Амгалан) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Орхонтуул)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  С.АМГАЛАН